

**ХОРЬДУГААР ЗУУНЫ НЭРТ ЭРДЭМТЭН, МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН
ШАГНАЛТ НАМГАРЫН ЛОНЖИД АГСНЫ НАМТАР, ШИНЖЛЭХ УХААНД
ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР (1922-2004)**

**BIOGRAPHY AND CONTRIBUTION TO SCIENCE OF LONJID NAMGAR (1922-2004),
THE FAMOUS SCIENTIST OF THE 20th CENTURY AND THE MONGOLIAN STATE
AWARD RECIPIENT**



Монгол улсын төрийн соёрхолт, нэрт эрдэмтэн Намгарын Лонжид агсан 1922 онд Архангай аймгийн Хотонт сумын нутаг Баянхошуу гэдэг газар жирийн нэг малчин ардын хүү болон мэндэлжээ. Н.Лонжид нь 1929-1939 онуудад Улаанбаатар хотод бага сургууль, Нисэхийн дунд сургууль, Намын дээд, Багшийн дээд сургуулийг тус тус дүүргэжээ. 1954-1958 онуудад ОХУ-ын Ломоносовын нэрэмжит улсын их сургуулийн Геологийн факультетын Геокриологийн тэнхимийг Цэвдэг судлалын мэргэжлээр мэргэшиж төгссөн. 1968 онд “БНМАУ-ын нутаг дэвсгэрийн олон жилийн цэвдгийн газарзүйн тархалт, криогений үзэгдэл” сэдвээр Газарзүйн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан.

Н.Лонжид агсны санаачилгаар БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1960 оны 6-р сарын 17 өдрийн 272 тоот тогтоолын дагуу Цэвдэг судлалын төв станцыг Улаанбаатар хотод байгуулсан. Тус станцыг Н.Лонжид агсан удирдаж, нийт 23 хүний орон тоотой ажиллаж байв. Энэхүү станц нь Завхан аймгийн Тосонцэнгэл, Дорнод аймгийн Чойбалсан сум, Төв аймгийн Налайхын районд салбар станцтай байв. Тэрээр Засгийн газарт соёл гэгээрлийн байцаагч, хүн эмнэлэг, авто тээврийн техникумд багш, хичээлийн эрхлэгч, Монгол Улсын Их сургуульд багш, Шинжлэх ухааны хүрээлэнгийн Газарзүйн тасагт эрдэм шинжилгээний ажилтан, Улсын барилгын зургийн институтэд инженер-геологийн товчооны дарга, Шинжлэх ухааны академийн Байгалийн хөргөлт судлалын эрдэм шинжилгээний төвийн захирал, Газарзүй Цэвдэг судлалын хүрээлэнд эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, лабораторийн эрхлэгчээр тус тус ажиллаж байлаа. Улс орны бүтээн байгуулалтын их ажилд нийтдээ 60 гаруй жил, үүнээс Шинжлэх ухааны академид 44 жил ажиллажээ. Н.Лонжид нь цэвдэг судлалын онол аргагүйг боловруулах лабораторийн материаллаг баазыг бэхжүүлэх, боловсон хүчин бэлтгэх нөр их ажлыг гүйцэтгэсэн нь цэвдэг судлалын шинжлэх ухааныг үндэслэгч төдийгүй Монгол улсын шинжлэх ухааныг хөгжүүлэхэд өөрийн эрдэм мэдлэг, авьяас чадвараа дайчлан ажиллаж байсан нэрт эрдэмтэн юм.

Н.Лонжид Монгол орны цэвдэгт ул хөрс уулын чулуулаг ба хөрсний улирлын хөлдөлтийн горимыг судалсны үр дүнд санаанд оромгүй мөсөн барилга байгууламж барьж, ашиглах техникийн шийдэл технологи боловсруулж байсан. Мөсний физик, механик шинж дулааны физикийн горим, параметрууд, Монгол орны уур амьсгалын мөчлөгүүд, хуурай гандуу байдал зэргийг прогнозлон судалсны үр дүнд цул мөсөн барилгын шийдэл зураг, технологи зохиох суурь үндэслэл болж байжээ. Энэхүү мөсөн барилга байгууламж нь байгаль техникийн холбоог нягт уялдуулсан байгалийн асар их хүйтний энергийг аж ахуйд ашиглаж эхлэх дорвитой шинэ бүтээл болсон.

Эдгээр технологи, шинэ санааг ашиглаж 1962 онд Улаанбаатар хотод 500, 1000 тонн багтаамжтай анхны мөсөн зоорийг бариулж, ашиглалтад өгсөн нь эдийн засгийн төдийгүй хүнсний аюулгүй байдалд чухал ач холбогдолтой бүтээгдэхүүн болсон юм. Тэрээр ерөнхий сайд Ю.Цэдэнбалын даалгавраар Улаанбаатар хотын ард иргэдийн хүнсний хэрэгцээний мах хадгалах нийт 1500 тонны багтаамжтай 2 мөсөн зоорь Хүүшийн аманд 1961-1962 онд, Бага залаатын аманд 500, 1000 тонны багтаамжтай 2 мөсөн зоорь 1963-1964 онд, Төр хурахын аманд 300 тонны зоорь 1975 онд, Мөрөнд 200 тонны зоорь 1980 онд, Хужир буланд 200 тонны зоорь 1982 онд, Хужиртад 200 тонны зоорь 1983 онд, Арлын цэргийн 178 дугаар ангид 100 тонны зоорь 1983 онд, Хотын захиргааны захиалгаар Хүрэлтогоотод 1000 тонны зоорь 1988 онд тус тус барьж байгуулсан.

Цул мөсөн зоорь нь Нийслэлийн ард иргэдийн хэрэгцээний хүнсний олон мянган тонн махыг 1962-1995 онуудад бага зардлаар чанартай хадгалж ирсэн нь ард иргэдийн талархлыг ихээр хүлээж байсан. Улсад мөсөн зоорины асуудлыг шийдвэрлэснээр эдийн засагчдын тооцоогоор 1995 оны байдлаар улсын сан хөмрөгт 1 тэрбум 823 сая төгрөгийн ашиг оруулсан гэдэг тоо баримт бий.

Европын нийгэмлэгээс эрхлэн гаргадаг Английн Манчестерийн их сургуулийн “Дэлхийн тэргүүний хүний толь бичиг” цувралын №27-р бүтээлд доктор Н.Лонжидын тухай нийтэлсэн байна. Тэрээр цэвдгийг судалж, мөсөн зоорь барьж, хүнсний бүтээгдэхүүн хадгалах их үйлсэд сүүлийн 40 гаруй жилийнхээ судалгааны ажлыг зориулсан бөгөөд энэ нь дэлхийн олон оронд сайн туршлага өгсөн түүхтэй. Төр засаг нэрт эрдэмтний энэхүү ажлыг үнэлж БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн шийдвэрээр “Байгалийн хөргөлтөд цул мөсөн зоорь” бүтээлээр нь 1988 онд “Төрийн соёрхол” цол, тэмдгийг олгож байжээ.

Н.Лонжид агсан “Монгол орны улирлын ба олон жилийн цэвдэг чулуулаг” (1963), “Жигд хөргөлттэй мөсөн агуулах” (1964), “Монгол орны олон жилийн цэвдэг чулуулаг” (1969), “Байгалийн хөргөлтөөр өнжмөл цэвдэг үүсгэх чулуун зоорь” (1979), “Хүнсний бүтээгдэхүүн хадгалах мөсөн зоорь” (1986), “Монгол орны инженер-геологийн нөхцөл”, “Монгол орны цэвдэг, цэвдэгт үзэгдлийн газарзүйн тархалт 1:2500 000 масштабтай анхны зураг” (1968) зэрэг томоохон бүтээлүүд нь Монгол орны цэвдгийн судалгааны тулгийн чулууг тавилцсан анхны бүтээлүүд юм. Түүнчлэн монгол орны нутгийн 60% нь цэвдгийн тархалттай түүнд 32518 шоо метр орчим эзлэхүүнтэй мөс, хүйтэн жавар цэнэг хадгалагдаж, хүйтний асар их энергийг бүрдүүлдэг болохыг тогтоосон.

Н.Лонжид агсны удирдаж байсан цэвдэг судлалын секторын судлаачид тодорхой бүс нутгийн цэвдэг ул хөрс, чулуулгийн тархалт, температурын нөхцөл, улирлын хөлдөлт гэсэлтийн горим, идвэхтэй давхаргын физик шинж чанарыг голчлон судалсан байдаг. Тэрээр цэвдэг судлалын секторын залуу судлаачдыг мэргэжлийн чиглэлээр ОХУ-ын их, дээд сургууль, дотоодын их сургуулиудад мэргэжүүлэн бэлтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан юм.

Н.Лонжид нь судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд тулгуурлан манай орны цэвдэгтэй Баянхонгор аймаг, Галуут сум, Говь-Алтай аймгийн Эрдэнэ сум гэх мэт 30 гаруй төв сууринг цэвдэггүй, ул хөрсний суулт үүсэж, барилга байшинд ан цав өгдөггүй газарт нүүлгэн шилжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан.

Нэрт эрдэмтэн судалгаа шинжилгээний ажлын үр дүнгээрээ патент 1, шинэ бүтээл 1, оновчтой санал 3-ыг тус тус боловсруулснаас “Мөсөн барилга”, “Зоорь” бүтээлүүд нь гадаад, дотоодын асар олон хүний талархал хүлээж ОХУ, Герман, БНХАУ, Швед, Их Британи зэрэг олон орны хэвлэл мэдээлэлд нийтлэгдсэн байна.

Н.Лонжид агсан улсад ажиллах хугацаандаа ерөнхий боловсролын сургууль, техникум, их дээд сургуулиудад багшилж нийт 20 орчим оюутны дипломын ажил, 10 докторын ажил удирдан хамгаалуулж, нийт 50 гаруй хүнийг өөрийн мэргэжлийн дагуу дадлагажуулан мэргэшүүлж Монгол улсын шинжлэх ухаан, боловсролын салбарт үнэтэй хувь нэмэр оруулсан. Улс орны бүтээн байгуулалтын ажилд нийтдээ 60 гаруй жил, үүнээс Шинжлэх ухааны академид 44 жил ажиллажээ. Энэ хугацаанд нэгэн сэдэвт бүтээл 10, эрдэм шинжилгээний болон хялбарчилсан өгүүлэл 100 гаруйг бичиж гадаад, дотоодын хэвлэлд нийтлүүлсэн байна.

Их Британийн нийслэл Лондон хотын Манчестерийн их сургуулийн намтар судлалын төвөөс Монгол орны цэвдэг чулуулаг, байгалийн хөргөлт, энерги цэнэгээр хүнсний бүтээгдэхүүн хадгалах мөсөн барилга, зоорь гэх мэт оюуны бүтээлүүдийг үнэлж 1999 онд хэвлэгдэн гарсан “XX зууны Тэргүүний Хүн” хэмээх толь бичигт оруулсан байдаг. Улмаар 2000 онд АНУ-ын “Глобал 50” хэмээх намтар судлалын төвөөс нэрт

эрдэмтэн Н.Лонжид агсныг “XX зууны Лидер”-ээр өргөмжлөн нийтэлжээ. Н.Лонжид агсныг Монгол улсын төр засгаас Төрийн Соёрхол, Алтан гадас одон, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, ойн медалиудаар тус тус шагнуулж байсан. Мөн өнжмөл цэвдэг үүсгэх зүй тогтлыг үндэслэн зохиосон мөсөн хөргөлттэй чулуун зоорь барьж, ашиглалтад өгснөөр Монгол улсын ШУА-ийн дээд шагнал хүртэж байсан. Тэрээр 1996 онд Парисын олон улсын засгийн газар хоорондын Хөргөлтийн хүрээлэнгийн хүндэт гишүүнээр сонгогдож, олон улсад нэр хүндтэй “Марий Кюри”-ийн дурсгалын мөнгөн медалиар шагнагдаж байжээ. Мөн Япон улсын доктор, профессор М.Кобияама манай оронд хүрэлцэн ирж Н.Лонжид агснаас “Мөнх цэвдгийн мөсөн зоорь” сэдвээр тусгайлан заавар, зөвлөмж авч, туршлага судалж авч байсан нь тухайн үед Монгол эрдэмтдийн нэр хүндийг олон улсын хэмжээнд өндөрт өргөж байсан түүхтэй.

Нэрт эрдэмтэн Н.Лонжид агсны эрдэм судлалын онолын болон практикийн ач холбогдолтой судалгаа шинжилгээний ажил нь Монголын цэвдэг судлалын шинжлэх ухааны үндэс, суурийг тавьсан. Үүнээс гадна дэлхийн цэвдгийн судалгаанд Монгол орны цэвдгийн тархалтыг тэмдэглэн оруулснаараа цэвдэг судлалын шинжлэх ухаанд үнэтэй хувь нэмэр оруулсан. Иймд түүний шинжлэх ухаан оруулсан хувь нэмэр, нөр их хөдөлмөр бүтээлийг хүндэтгэн өргөмжилж 2012 онд Газарзүйн хүрээлэнгийн Цэвдэг судлалыг секторыг Нэрт эрдэмтэн, Төрийн соёрхолт Намгарын Лонжидын нэрэмжит сектор болгож байсан түүхтэй.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн эрдмийн хамт олон нэрт эрдэмтэн мэндэлсний 100 жилийн ойтой холбогдуулан Н.Лонжид агсны амьдрал, оюуны бүтээлийг оюутан залуус, эрдэм мэдлэг сонирхогч хүн бүхэнд таниулах зорилготойгоор цахим дурсамж, нийтлэл түгээх, лекц, семинар эрдэм шинжилгээний хурлын тусгайлсан хэсэг зохиох зэрэг олон ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

ШУА, Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн,

Цэвдэг судлалын салбар

2022.12.29